



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.001>

Understanding National Security through Strategic Reading: A New Theoretical and Methodological Framework

A.Tuvshintugs

Expert Group, National Security Council of Mongolia

Received: 07 June 2026

Revised: 02 July 2026

Accepted: 09 July 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

Contemporary strategic environments are increasingly characterized by interconnected and multi-level transformations driven by geopolitical competition, geo-economic interdependence, technological change, and the evolution of the information environment. These developments have exposed the limitations of conventional approaches that interpret national security primarily through the lenses of threats and risks. This article aims to establish the theoretical and methodological foundations of understanding national security through strategic reading and to develop the underlying logic of an analytical model for interpreting national security from this perspective. The study employs conceptual analysis, comparative interpretation, and theoretical analysis drawn from strategic studies and security studies.

The findings demonstrate that threat-centered reading and strategic reading represent two distinct analytical frameworks for understanding national security. While threat-centered reading focuses on identifying threats and risks and developing protective responses, strategic reading interprets security issues through the relationships among strategic situations, objectives, environment, opportunities, constraints, and strategic choices. On this basis, the study develops an analytical model of strategic reading for national security and argues that security issues should be understood not primarily in terms of the nature of threats, but through the logic by which strategic situations are constituted.

The study further shows that strategic reading is not intended to replace the threat-centered approach; rather, it broadens its explanatory scope by placing security issues within a wider strategic context. In this sense, strategic reading provides a theoretical and methodological foundation for understanding national security at the level of strategic situations rather than merely at the level of threats. The article argues that strategic reading constitutes an autonomous analytical framework that can contribute to the advancement of strategic studies and national security analysis in Mongolia.

Keywords: National Security; Strategic Reading; Strategic Conditions; Threat-Centered Reading; Strategic Analysis; Analytical Framework.

Үндэсний аюулгүй байдлыг стратегийн уншлагын түвшинд ойлгох нь: Онол-арга зүйн шинэ хүрээ

А.Түвшинтөгс

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шинжлэх ухааны академийн хэргийн газар

ХУРААНГУЙ

Орчин үеийн стратегийн орчин дахь харилцан хамааралтай, олон түвшний өөрчлөлтүүд нь үндэсний аюулгүй байдлын асуудлыг зөвхөн аюул занал, эрсдэлийн хүрээнд тайлбарлах уламжлалт хандлагын хязгаарлалтыг улам тодорхой болгож байна. Энэхүү өгүүллийн зорилго нь үндэсний аюулгүй байдлыг стратегийн уншлагын түвшинд ойлгох онол-арга зүйн үндсийг тодорхойлж, түүнийг тайлбарлах аналитик загварын үндсэн логикийг боловсруулахад оришино. Судалгаанд ойлголтын шинжилгээ, харьцуулсан тайлбар, стратеги судлал болон аюулгүй байдал судлалын онолын тайлбарын аргыг ашиглав.

Судалгааны үр дүнд аюул төвтэй уншлага болон стратегийн уншлага нь үндэсний аюулгүй байдлыг тайлбарлах хоёр өөр аналитик хүрээ болохыг тогтоов. Аюул төвтэй уншлага нь аюул занал, эрсдэлийг тодорхойлох, хамгаалалтын арга хэмжээг боловсруулахад чиглэдэг бол стратегийн уншлага нь аюулгүй байдлын асуудлыг стратегийн нөхцөл байдал, зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголтын харилцан хамаарлын хүрээнд тайлбарлахад чиглэдэг болохыг харуулав. Үүний үндсэн дээр үндэсний аюулгүй байдлын стратегийн уншлагын аналитик загварыг боловсруулж, аюулгүй байдлын асуудлыг аюулын шинж чанараар бус, харин стратегийн нөхцөл байдал бүрэлдэх логикийн ойлгох боломжийг тодорхойлов.

Судалгааны үр дүн нь стратегийн уншлага нь аюул төвтэй хандлагыг орлох бус, харин түүнийг илүү өргөн стратегийн хүрээнд тайлбарлах боломж олгодог болохыг харуулж байна. Энэ утгаараа стратегийн уншлага нь үндэсний аюулгүй байдлыг аюулын түвшинд бус, стратегийн нөхцөл байдлын түвшинд ойлгох онол-арга зүйн боломжийг нээж, Монголын стратегийн судалгаа болон үндэсний аюулгүй байдлын шинжилгээнд ашиглаж болох бие даасан аналитик хүрээ болохыг нотлон харуулж байна.

Түлхүүр үг: Үндэсний аюулгүй байдал, стратегийн уншлага, стратегийн нөхцөл байдал, аюул төвтэй уншлага, стратегийн шинжилгээ, шинжилгээний хүрээ.

ОРШИЛ

Орчин үеийн стратегийн орчин нь улс төр, эдийн засаг, технологи, мэдээлэл, нийгмийн өөрчлөлтүүдийн улам бүр нягтарч буй харилцан хамаарлаар тодорхойлогдох болсон нь үндэсний аюулгүй байдлын асуудлыг ойлгох уламжлалт арга хандлагуудад шинэ шаардлага тавьж байна. Үндэсний аюулгүй байдлыг тайлбарлахад аюул занал, эрсдэлийн шинжилгээ чухал ач холбогдолтой хэвээр байгаа боловч өнөөгийн олон асуудал нь дан ганц аюулын илрэл бус, харин илүү өргөн хүрээний стратегийн нөхцөл байдлын үр дүн болж байна (Freedman 2013, 1-16; Gray 2010, 1-18). Иймээс үндэсний аюулгүй байдлыг зөвхөн аюулын ангилал, эрсдэлийн үнэлгээний хүрээнд тайлбарлах нь түүний үүсэл, чиглэл, үр дагавар болон стратегийн утгыг бүрэн ойлгоход хүрэлцэхгүй байж болох асуудал урган гарч байна.

Аюулгүй байдал судлалын сонгодог бүтээлүүд үндэсний аюулгүй байдлыг гол төлөв аюул занал, эрсдэлийн хүрээнд тайлбарлахад төвлөрч ирсэн бол стратеги судлалын бүтээлүүд стратегийг өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг тайлбарлах өргөн хүрээний логик болгон авч үзэх хандлага аажмаар хүчтэй болсон. Гэвч эдгээр хоёр чиглэлийн уулзвар дээр үндэсний аюулгүй байдлыг стратегийн уншлагын түвшинд

тайлбарлах нэгдсэн онол-арга зүйн хүрээ Монгол хэл дээр хараахан системтэй томъёологдоогүй байна. Энэхүү судалгаа нь энэ онол-арга зүйн орон зайг нөхөх оролдлого болно.

Энэ нөхцөл байдал нь үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд хэрхэн ойлгож болох вэ гэсэн онол-арга зүйн асуудлыг дэвшүүлж байна. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг зөвхөн “ямар аюул нүүрлэж байна вэ?” гэсэн асуултаар бус, харин “ямар стратегийн нөхцөл байдал бүрэлдэж байна вэ?” гэсэн асуултаар тайлбарлах боломж бий эсэх нь энэхүү судалгааны үндсэн асуудал болно.

Судалгааны зорилго, зорилт: Судалгааны зорилго нь үндэсний аюулгүй байдлыг стратегийн уншлагын түвшинд ойлгох онол-арга зүйн үндсийг тодорхойлж, түүнийг тайлбарлах аналитик загварын үндсэн логикийг боловсруулахад оршино.

Монгол Улсад үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, стратегийн асуудлаар хийсэн судалгаанууд нь үндсэндээ аюул занал, эрсдэлийн үнэлгээ, батлан хамгаалах бодлого, салбарын аюулгүй байдлын асуудлыг тайлбарлахад төвлөрч ирсэн (С.Пүрэвдорж 2025; Б.Ширнэн 2025; Аюулгүй байдал, стратеги тойм 2023) бөгөөд энэ чиглэлээр тодорхой онол, арга зүйн суурь бүрдүүлжээ. Харин үндэсний аюулгүй байдлыг стратегийн нөхцөл байдал, зорилго, сонголтын харилцан хамаарлын түвшинд тайлбарлах нэгдсэн аналитик хүрээний асуудал харьцангуй бага судлагдсан хэвээр байна. Энэхүү судалгаа нь уг арга зүйн орон зайг нөхөх зорилготой болно.

Судалгааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд **дараах зорилтыг дэвшүүлэв**. Үүнд: нэгдүгээрт, стратегийн уншлагын танин мэдэхүйн байрлал болон үндсэн асуултуудыг тодорхойлох; хоёрдугаарт, аюул төвтэй уншлага болон стратегийн уншлагын ялгааг тайлбарлах; гуравдугаарт, үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд унших аналитик загварын логикийг боловсруулах; дөрөвдүгээрт, энэхүү хандлагын Монголын стратегийн судалгаа болон үндэсний аюулгүй байдлын бодлогод өгөх ач холбогдлыг тодруулах явдал болно.

Судалгааны объект нь үндэсний аюулгүй байдлыг тайлбарлах онол-арга зүйн хандлагууд бөгөөд судлах зүйл нь үндэсний аюулгүй байдлыг стратегийн уншлагын түвшинд ойлгох аналитик логик, түүний арга зүйн боломж мөн.

Судалгааны арга зүй: Энэхүү судалгаа нь шинэ эмпирик өгөгдөл боловсруулах бус, үндэсний аюулгүй байдлыг тайлбарлах онолын хүрээг дахин томъёолох зорилготой тул ойлголтын шинжилгээ болон харьцуулсан тайлбарын аргыг үндсэн арга болгон сонгож ашигласан болно. Ойлголтын шинжилгээ нь аюул төвтэй болон стратегийн уншлагын ялгааг тодорхойлоход, харьцуулсан тайлбар нь тэдгээрийн шинжилгээний объект, үндсэн асуулт, тайлбарлах логикийн ялгааг гаргахад, стратегийн шинжилгээний онолын тайлбар нь үндэсний аюулгүй байдлыг стратегийн нөхцөл байдлын түвшинд ойлгох аналитик загварын үндсийг боловсруулахад чиглэв. Ойлголтын шинжилгээг хэрэглэхдээ ойлголтын бүрдэл, хүрээ, тайлбарын нэгжийг ялган тодорхойлох талаар Sartori (1970), Collier ба Mahon (1993), Goertz (2006), George & Bennett (2005)-ийн арга зүйн зарчмыг баримталсан бөгөөд харьцуулсан тайлбарыг үндэсний аюулгүй байдлыг унших хоёр өөр аналитик хүрээний ялгааг тодруулахад ашиглав.

Энэхүү өгүүлэл нь үндэсний аюулгүй байдлыг тайлбарлах шинэ онол

боловсруулах зорилго агуулаагүй болно. Харин стратеги судлал болон аюулгүй байдал судлалын онолын зарим гол санааг нэгтгэн, үндэсний аюулгүй байдлыг аюул төвтэй тайлбарын хүрээнээс давуулан стратегийн нөхцөл байдал, зорилго, боломж, хязгаарлалт, сонголтын харилцааны хүрээнд ойлгох аналитик загварын боломжийг тодруулахыг зорьсон болно.

Өгүүлэл нь үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэгт стратегийн уншлагын онол-арга зүйн үндсийг авч үзэж, түүний танин мэдэхүйн байрлал болон үндсэн асуултуудыг тодорхойлно. Хоёрдугаар хэсэгт аюул төвтэй уншлага болон стратегийн уншлагын ялгааг харьцуулан шинжилж, стратегийн уншлагын аналитик онцлогийг тайлбарлана. Гуравдугаар хэсэгт үндэсний аюулгүй байдлын стратегийн уншлагын аналитик загварыг боловсруулна, Хэлэлцүүлэг хэсэгт түүний Монголын стратегийн судалгаа болон үндэсний аюулгүй байдлын бодлогод өгөх ач холбогдлыг авч үзнэ. Улмаар дүгнэлт хэсэгт судалгааны үндсэн гаргалгаа болон онол-арга зүйн ач холбогдлыг нэгтгэн дэвшүүлэв.

Нэг. Стратегийн уншлагын онол-арга зүйн үндэс

1.1. Стратегийн уншлагын танин мэдэхүйн байрлал

Үндэсний аюулгүй байдлын асуудлыг тайлбарлах уламжлалт хандлага нь ихэвчлэн аюул занал, эрсдэл, хамгаалалтын арга хэмжээ зэрэг шууд илэрч буй үзэгдэлд төвлөрдөг. Ийм хандлага нь ямар аюул тулгарч байгаа, түүний эх үүсвэр юу болох, түүнд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх зэрэг асуудлыг тодорхойлоход ач холбогдолтой боловч тухайн үзэгдлийг бий болгож буй өргөн хүрээний нөхцөл байдал, харилцан хамаарал, чиг хандлагыг бүрэн тайлбарлаж чаддаггүй (Walt 1991; Buzan 1991, 1–38; Baldwin 1997). Өөрөөр хэлбэл, үйл явдал өөрөө харагддаг боловч түүнийг нөхцөлдүүлж буй стратегийн орчин тэр бүр харагддаггүй. Иймээс үндэсний аюулгүй байдлыг зөвхөн аюулын хүрээнд бус, харин түүнийг бүрдүүлж буй нөхцөл байдал, чиг хандлага, боломж, хязгаарлалтын нэгдэл болгон ойлгох танин мэдэхүйн өөр байрлал шаардлагатай болж байна (Freedman 2013, ix–xii; Gray 2010, 1–18; А.А. Свечин 1927а).

Стратегийг төлөвлөгөө, зорилтын жагсаалт, эсвэл үйл ажиллагааны хөтөлбөртэй адилтган ойлгох нь түгээмэл боловч ийм ойлголт нь стратегийн мөн чанарыг бүрэн илэрхийлж чаддаггүй. Стратеги нь урьдчилан тогтоосон төлөвлөгөөг хэрэгжүүлэх техникийн арга бус, харин байнга өөрчлөгдөж буй орчны дунд чиглэл тогтоох оюуны үйл ажиллагаа юм. Түүний гол зорилго нь тодорхой бус байдлыг арилгах бус, харин тодорхой бус орчны дунд утга учрыг нь тайлбарлаж, зорилго болон үйл ажиллагааны хоорондын уялдааг ойлгоход оршино. Ийм утгаараа стратеги нь баримт бичиг биш, харин нөхцөл байдлыг ойлгох логик бөгөөд стратегийн уншлага нь төлөвлөгөө унших үйл ажиллагаа бус, харин өөрчлөгдөж буй орчныг утгачилж ойлгох танин мэдэхүйн арга юм (А.А. Свечин 1927а).

Эндээс стратегийн уншлагын мөн чанар тодорхой болж эхэлнэ. Стратегийн уншлага нь үйл явдлыг дангаар нь ажиглах бус, харин тухайн үйл явдлыг бий болгож буй нөхцөл байдлыг тайлбарлахыг зорьдог. Түүний анхаарлын төвд аюул занал өөрөө бус, харин зорилго, орчин, хүч, боломж, хязгаарлалтын харилцан хамаарлаар бүрэлдэх стратегийн нөхцөл байдал оршино. Нэг үзэгдэл өөр өөр нөхцөл байдалд өөр стратегийн утгатай байж болох бөгөөд стратегийн уншлагын

зорилго нь энэ утгыг илрүүлэхэд чиглэдэг. Иймээс стратегийн уншлага нь юу болсон бэ гэсэн асуултаас илүүтэйгээр энэ нөхцөл байдал ямар утгатай вэ гэсэн асуултад төвлөрдөг танин мэдэхүйн байрлал юм. Энэ утгаараа стратегийн уншлага нь аюулыг тайлбарлах бус, харин орчин, зорилго, боломж, хүчний харилцаанаас бүрдэх стратегийн бодит байдлыг тайлбарлахыг зорьдог (Gray 2010, 19–38; Freedman 2013, 1–16; Heuser 2010, 1–20, 447–70; Снесарев А.Е 2002, 35–52; Кокошин А.А 2014).

Хэрэв стратегийн уншлага нь үндэсний аюулгүй байдлыг ойлгох ийм танин мэдэхүйн байрлал мөн бол түүний дараагийн зайлшгүй асуудал нь уг нөхцөл байдлыг ямар асуултаар тайлбарлах вэ гэсэн асуудал болно. Өөрөөр хэлбэл, стратегийн уншлагын онолын үндэс нь стратегийн нөхцөл байдлыг ойлгох шаардлагыг тогтоож байгаа бол дараагийн алхам нь түүнийг шинжлэхэд ашиглах үндсэн асуултуудыг тодорхойлох явдал юм. Иймээс стратегийн уншлагын танин мэдэхүйн байрлалаас стратегийн уншлагын үндсэн асуулт руу шилжих шаардлага урган гарч байна (Yarger 2006; Кокошин А.А 2019; А.А. Свечин 1927a).

1.2. Стратегийн уншлагын үндсэн асуулт

Стратегийн уншлагын танин мэдэхүйн байрлал нь үндэсний аюулгүй байдлыг үйл явдал, аюул занал, эрсдэлийн хүрээнээс илүү өргөн хүрээтэй нөхцөл байдлын түвшинд ойлгох шаардлагыг дэвшүүлдэг. Гэвч аливаа нөхцөл байдлыг ойлгох үйл явц нь зөвхөн мэдээлэл цуглуулах, баримтыг ангилах, эсвэл үзэгдлийг тайлбарлахаар хязгаарлагдахгүй. Тухайн бодит байдлыг ямар өнцгөөс харах, ямар утгаар ойлгох нь юуны өмнө түүнд хандаж буй асуултаас шалтгаалдаг. Иймээс стратегийн шинжилгээний чанар нь зөвхөн ашигласан мэдээллийн хэмжээнээс бус, харин ямар асуултаар бодит байдлыг тайлбарлахыг оролдож байгаагаас ихээхэн хамаарна. Стратегийн уншлага нь бодит байдлыг ойлгох асуултын тогтолцоог тодорхойлдог (Yarger 2006; А.А. Свечин 1927b).

Эндээс аюул төвтэй асуулт болон стратегийн асуултын ялгаа тодорхой болж эхэлдэг. Аюул төвтэй уншлага нь ямар аюул үүсэж байна вэ, ямар эрсдэл нэмэгдэж байна вэ, түүнд хэрхэн хариу үзүүлэх вэ гэсэн асуудалд төвлөрдөг бол стратегийн уншлага нь ямар нөхцөл байдал бүрэлдэж байна вэ, ямар зорилго дарамтад орж байна вэ, ямар боломж болон хязгаар бий болж байна вэ гэсэн асуудлыг авч үздэг. Ийнхүү стратегийн уншлагын онцлог нь аюулыг бус, түүнийг нөхцөлдүүлж буй нөхцөл байдлыг тайлбарлах асуултуудыг дэвшүүлэхэд оршино (Rumelt 2011; Yarger 2006; Кокошин А.А 2019).

Стратегийн уншлагын үндсэн асуултууд нь бие даасан жагсаалт бус, харин нэгэн цогц тайлбарын тогтолцоо юм. Энэхүү тогтолцоо нь орчин хэрхэн өөрчлөгдөж байна вэ гэсэн асуултаас эхэлж, тухайн өөрчлөлт ямар зорилгод нөлөөлж байна вэ гэсэн асуудал руу шилжинэ. Үүнээс цааш зорилгыг хэрэгжүүлэхэд ямар хүч, нөөц, боломж ашиглагдах боломжтой, тэдгээрийг ямар хязгаарлалт нөхцөлдүүлж байна, улмаар ямар сонголтууд нээлттэй хэвээр үлдэж байна вэ гэсэн асуултууд урган гардаг. Иймээс стратегийн уншлага нь аюулын шинж чанарыг бус, зорилго, орчин, хүч, боломж, хязгаар болон сонголтын харилцан хамаарлыг тайлбарлах асуултын тогтолцоо мөн (Gray 1999, 17–32; Freedman 2013, 1–16; А.А. Свечин 1927b).

Ийнхүү стратегийн уншлага нь үндэсний аюулгүй байдлыг тайлбарлахад

ашиглах асуултын тогтолцоог тодорхойлж байна. Харин эдгээр асуултууд бодитойгоор ямар өөр үр дүнд хүргэдэг вэ гэсэн асуудал дараагийн шатанд гарч ирнэ. Иймээс үндэсний аюулгүй байдлыг унших хоёр өөр хандлагын ялгааг авч үзэх шаардлага үүсэж байна (Yarger 2006).

Хоёр. Үндэсний аюулгүй байдлыг унших хоёр хандлага

2.1. Аюул төвтэй уншлагын хязгаар

Үндэсний аюулгүй байдлын судалгаанд аюул төвтэй уншлага урт хугацаанд давамгайл байр суурь эзэлж ирсэн бөгөөд түүний гол анхаарал нь аюул заналыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, хамгаалах арга хэмжээг тодорхойлоход чиглэж байв. Энэхүү хандлага нь аюулгүй байдлыг хамгаалагдах үнэт зүйл болон түүнд учирч буй заналхийллийн харилцаагаар тайлбарлах боломжийг бүрдүүлсэн төдийгүй бодит аюулыг таних, эрэмбэлэх, түүнд хариу үйлдэл боловсруулахад өндөр үр ашигтай болохоо харуулсан. Иймээс аюул төвтэй уншлага нь үндэсний аюулгүй байдлын судалгааны суурь арга хэвээр байгаа бөгөөд түүний ач холбогдол өнөөдөр ч буураагүй байна (Walt 1991; Buzan 1991).

Аюул төвтэй уншлага нь тодорхой эх үүсвэртэй, харьцангуй илэрхий шинжтэй, нөлөөллийн хүрээг нь тодорхойлж болох асуудлыг тайлбарлахад оновчтой хэвээр байна. Энэ тохиолдолд шинжилгээний үндсэн зорилго нь ямар аюул үүсэж байна вэ, түүний эх үүсвэр хаана байна вэ, ямар үр дагавар учруулах вэ гэсэн асуултад хариулахад оршдог. Ийм аналитик хүрээ нь шийдвэр гаргагчдад эрсдэлийг тодорхойлж, хамгаалах арга хэмжээг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг өгдөг. Өөрөөр хэлбэл, аюул төвтэй уншлагын давуу тал нь аюулыг төв объект болгон авч үздэгт бус, харин тодорхой заналхийллийг таних, үнэлэхэд чиглэсэн төвлөрсөн тайлбарын хүрээг бүрдүүлдэгт оршино (Baldwin 1997).

Гэвч орчин үеийн стратегийн орчин улам бүр харилцан хамааралтай, олон хүчин зүйлийн огтлолцлоор тодорхойлогдох болсон нь аюул төвтэй уншлагын аналитик хүрээний зарим хязгаарыг ил болгож байна. Өнөөдөр эдийн засгийн өөрчлөлт, технологийн шинэчлэл, мэдээллийн орчны хувьсал, нийлүүлэлтийн сүлжээний эмзэг байдал, төрийн удирдлагын тогтвортой байдал зэрэг олон үзэгдэл нь дан ганц аюулын ангиллаар тайлбарлагдахгүй болсон. Учир нь эдгээр нь нэг эх үүсвэртэй заналхийлэл бус, харин олон хүчин зүйлийн харилцан үйлчлэлээс бүрэлдсэн нөхцөл байдлын илрэл байдаг. Ийм нөхцөлд асуудлын мөн чанар нь ямар аюул үүсэв гэдэгт бус, харин ямар нөхцөл байдал бүрэлдэж байна вэ гэдэгт оршдог. Өөрөөр хэлбэл, аюул нь тухайн нөхцөл байдлын нэг илрэл байж болох боловч нөхцөл байдлыг бүхэлд нь төлөөлж чаддаггүй (Buzan 1991; Ullman 1983).

Иймээс үндэсний аюулгүй байдлын асуудал улам бүр аюулын асуудлаас гадна стратегийн асуудал болж хувирч байна. Энэ нь аюул занал ач холбогдлоо алдсан гэсэн үг биш юм. Харин асуудлыг зөвхөн аюулын түвшинд тайлбарлах нь түүний утга, чиглэл, урт хугацааны үр дагаврыг бүрэн ойлгоход хүрэлцэхгүй болж байгааг харуулж байна. Асуудлын гол цөм нь ямар аюул байна вэ гэсэн асуултад бус, харин өөрчлөгдөж буй нөхцөл байдалд зорилго, орчин, боломж, хязгаар хэрхэн харилцан үйлчилж байна вэ гэсэн асуудалд шилжиж эхэлж байна. Энэ утгаараа үндэсний аюулгүй байдлын олон асуудал нь аюулын тоо хэмжээгээр бус, харин нөхцөл байдлын утга, чиглэл, үр дагавраар тодорхойлогдох болжээ (Ullman 1983; Wæver 1995).


Ийнхүү аюул төвтэй уншлага нь аюулыг таних, эрсдэлийг үнэлэхэд үр ашигтай хэвээр байгаа боловч орчин үеийн стратегийн нөхцөл байдлын нийлмэл шинжийг бүхэлд нь тайлбарлах боломж хязгаарлагдмал юм. Иймээс дараагийн асуудал нь үндэсний аюулгүй байдлыг аюулын хүрээнээс давсан өөр аналитик байрлалаас хэрхэн уншиж болох вэ гэсэн асуулт болж байна. Энэ нь үндэсний аюулгүй байдлыг тайлбарлах өөр хандлагын тухай асуудлыг дэвшүүлж байгаа бөгөөд үүнээс стратегийн уншлагын асуудал урган гарна (Walt 1991; Buzan 1991; Baldwin 1997).

2.2. Үндэсний аюулгүй байдлын стратегийн уншлага

Аюул төвтэй уншлага нь аюулыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэхэд үр ашигтай хэвээр байгаа боловч орчин үеийн стратегийн нөхцөл байдлын нийлмэл шинжийг бүхэлд нь тайлбарлахад хүрэлцэхгүй болж байна. Ийм нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг зөвхөн аюулын өнцгөөс бус, харин түүнийг нөхцөлдүүлж буй орчин, зорилго, боломж, хязгаарлалтын хүрээнд ойлгох шаардлага урган гардаг. Ийнхүү үндэсний аюулгүй байдлыг ойлгох асуудал нь аюулыг таних асуудлаас стратегийн нөхцөл байдлыг тайлбарлах асуудал руу шилжиж байна (Gray 2010, 1–18; A.A. Свечин 1927a).

Энэхүү өгүүлэлд хэрэглэж буй “стратегийн уншлага” гэдэг нь өмнөх судлаачдын нэр томьёог давтан хэрэглэсэн ойлголт бус, харин Freedman, Gray, Свечин нарын стратегийг нөхцөл байдлыг тайлбарлах логик гэж үзсэн нийтлэг санааг нэгтгэн боловсруулсан зохиогчийн аналитик томьёолол мөн. Иймээс энэхүү ойлголтын зорилго нь шинэ онол зохиох бус, харин тархай байрласан онолын санааг үндэсний аюулгүй байдлын шинжилгээнд хэрэглэж болох нэгэн цогц арга зүйн хүрээ болгон нэгтгэн тайлбарлахад оршино.

Стратегийн уншлагын үндсэн асуудал нь ямар стратегийн нөхцөл байдал бүрэлдэж байна вэ гэсэн асуултаас эхэлдэг. Үүнтэй зэрэгцэн ямар зорилго дарамтад орж байна, ямар боломж шинээр бий болж байна, ямар хязгаарлалт хүчтэй болж байна, улмаар ямар сонголтууд бодитой хэвээр үлдэж байна вэ гэсэн асуудлууд гарч ирдэг (Rumelt 2011; A.A. Свечин 1927a; Gray 2010, 19–38). Иймээс стратегийн уншлага нь мэдээллийг тайлбарлах бус, харин зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголтын хоорондын харилцааг тайлбарлахад чиглэнэ.



Зураг 1. Үндэсний аюулгүй байдлын стратегийн уншлагын шинжилгээний хүрээ

Эх сурвалж: Судалгааны үр дүнд үндэслэн зохиогчийн боловсруулсан шинжилгээний загвар.

Тайлбар. Энэхүү зураг нь үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд унших аналитик дарааллыг илэрхийлнэ. Стратегийн шинжилгээ нь орчныг дангаар нь дүрслэхээс бус, харин түүнийг үндэсний зорилгын хүрээнд тайлбарлах үйл явцаас эхэлдэг. Учир нь ижил орчин өөр өөр зорилго бүхий оролцогчдын хувьд өөр өөр стратегийн утга агуулгатай байдаг. Иймээс стратегийн нөхцөл байдал нь орчны объектив төлөв бус, харин стратегийн зорилго ба орчны харилцан үйлчлэлээс бүрэлдэх аналитик үр дүн юм. Энэ утгаараа стратегийн уншлагын гол зорилго нь орчны өөрчлөлтийг бүртгэхэд бус, харин тухайн нөхцөл байдал ямар стратегийн боломж, хязгаарлалт, сонголтыг бий болгож байгааг тайлбарлахад оршино.

Энэ үндсэн дээр стратегийн шинжилгээ нь стратегийн нөхцөл байдлыг тодорхойлсны дараа зорилго, боломж, хязгаарлалт, сонголтын харилцааг дараалсан байдлаар шинжилж, улмаар үндэсний аюулгүй байдлын стратегийн чиглэл, боломжит үр дүнг тайлбарладаг. Иймээс зурагт үзүүлсэн дараалал нь үйл ажиллагааны үе шат, бодлогын цикл, эсвэл шийдвэр гаргах алгоритм биш бөгөөд стратегийн нөхцөл байдлыг ойлгох танин мэдэхүйн аналитик логикийг илэрхийлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, энэхүү зураг нь аюулын дарааллыг бус, харин стратегийн утга хэрхэн бүрэлдэж байгааг тайлбарлах онол-арга зүйн хүрээг дүрсэлсэн болно.

2.3. Аюул төвтэй уншлага ба стратегийн уншлагын харьцуулсан шинжилгээ

Аюул төвтэй уншлагын хязгаар болон стратегийн уншлагын мөн чанарыг тус тусад нь тодорхойлсны дараа эдгээр хоёр хандлагын ялгааг системтэй харьцуулах шаардлага үүснэ. Энэ харьцуулалтын зорилго нь аль нэг хандлагыг зөв, нөгөөг

буруу гэж дүгнэхэд бус, харин тэдгээр нь үндэсний аюулгүй байдлыг өөр өөр асуулт, өөр өөр шинжилгээний объект, өөр өөр тайлбарын түвшнээс авч үздэг болохыг тодруулахад оршино. Иймээс энэ хэсэгт аюул төвтэй уншлага болон стратегийн уншлагыг өрсөлдөгч байрлал бус, харин үндэсний аюулгүй байдлыг ойлгох хоёр өөр аналитик хүрээ гэж авч үзнэ (George and Bennett 2005).

Аюул төвтэй уншлагын шинжилгээний төвд аюул занал оршдог бөгөөд түүний үндсэн асуулт нь ямар аюул үүсэж байна вэ гэдэг асуудал байдаг. Иймээс шинжилгээ нь аюулын эх үүсвэр, нөлөөлөл, эрсдэл болон хамгаалах арга хэмжээг тодорхойлоход чиглэдэг (Walt 1991).

Харин стратегийн уншлагын шинжилгээний төвд стратегийн нөхцөл байдал оршдог бөгөөд түүний үндсэн асуулт нь ямар стратегийн нөхцөл байдал бүрэлдэж байна вэ гэдэг асуудал байдаг. Иймээс шинжилгээ нь зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголтын харилцааг тайлбарлахад чиглэдэг (Freedman 2013, 1–16; Gray 2010).

Эдгээр хоёр хандлагын ялгаа нь нэр томьёоны ялгаа бус, харин шинжилгээний объектын ялгаа юм. Аюул төвтэй уншлага нь аюулыг төв объект болгон авч үздэг бол стратегийн уншлага нь стратегийн нөхцөл байдлыг төв объект болгон авч үздэг. Үүний улмаас тавьдаг асуулт, анхаарлын төв, тайлбарлах нэгж, шинжилгээний үр дүн өөр өөр байдаг. Иймээс аюул төвтэй уншлага нь хамгаалах шаардлагатай зүйл болон түүнд учирч буй заналхийллийн харилцааг тодруулдаг бол стратегийн уншлага нь зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголтын харилцаанаас үүсэж буй стратегийн утгыг тайлбарладаг (Collier and Mahon 1993).

Хүснэгт 1. Аюул төвтэй уншлага ба стратегийн уншлагын харьцуулсан аналитик хүрээ

Үзүүлэлт	Аюул төвтэй уншлага	Стратегийн уншлага
Танин мэдэхүйн байрлал	Аюулыг таних	Стратегийн нөхцөл байдлыг ойлгох
Гол асуулт	Ямар аюул байна вэ?	Ямар стратегийн нөхцөл байдал бүрэлдэж байна вэ?
Шинжилгээний объект	Аюул занал	Стратегийн нөхцөл байдал
Төв анхаарал	Эх үүсвэр, нөлөөлөл, хамгаалалт	Зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголт
Тайлбарлах нэгж	Аюул ба хамгаалагдах зүйл	Зорилго–орчин–боломж–хязгаарлалтын харилцаа
Үр дүн	Аюулын зураглал	Стратегийн нөхцөл байдлын тайлбар
Бодлогын чиглэл	Хамгаалах арга хэмжээ	Стратегийн сонголт
Цаг хугацааны чиглэл	Одоогийн аюул	Ирээдүйн үр дагавар

Эх сурвалж: Судалгааны үр дүнд үндэслэн зохиогчийн боловсруулсан шинжилгээний хүрээ.

Энэ харьцуулалтаас харахад стратегийн уншлага нь аюул төвтэй уншлагыг няцаах бус, харин түүний тайлбарын хүрээг өргөжүүлж байна. Аюул төвтэй уншлага аюулыг илрүүлэхэд хүчтэй бол стратегийн уншлага тухайн аюул ямар нөхцөл байдлын дотор үүсэж, ямар стратегийн утгатай болж байгааг ойлгоход чиглэдэг. Иймээс үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд унших нь аюулын тоо, төрөл, эх үүсвэрийг тодорхойлохоос илүү өргөн хүрээтэй бөгөөд нөхцөл байдлын утга, чиглэл, сонголтын хүрээг ойлгох асуудал мөн.

2.4. Үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд унших шинжилгээний загвар

Дээрх шинжилгээнээс харахад үндэсний аюулгүй байдлыг зөвхөн аюул занал, эрсдэлийн хүрээнд тайлбарлах нь стратегийн нөхцөл байдлын нийт логикийг бүрэн ойлгоход хүрэлцэхгүй байна. Аюул нь ихэвчлэн тухайн нөхцөл байдлын нэг илрэл байдаг бол стратегийн шийдвэр нь илүү өргөн хүрээний зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголтын харилцаан дунд бий болдог. Иймээс үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд ойлгохын тулд аюулын шинжилгээг нөхцөл байдлын шинжилгээнд нэгтгэн авч үзэх аналитик хүрээ шаардлагатай болж байна.

Энэхүү шаардлагад үндэслэн үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд унших аналитик загварыг санал болгож байна.

Стратегийн орчин. Уг загварын эхлэл нь стратегийн орчин юм. Стратегийн орчин нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нийлбэр бөгөөд үндэсний аюулгүй байдлын асуудал үүсэх суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Гэвч орчин өөрөө шууд стратегийн утга агуулдаггүй. Түүнийг тайлбарлах үйл явц буюу стратегийн уншлагаар дамжин орчны өөрчлөлтүүд стратегийн нөхцөл байдал болон ойлгогддог. Иймээс стратегийн уншлага нь мэдээлэл цуглуулах ажиллагаа бус, харин орчны өөрчлөлтүүдийг утгачилж ойлгох аналитик үйл явц юм.

Стратегийн нөхцөл байдал. Стратегийн уншлагын үр дүнд стратегийн нөхцөл байдал тодорхойлогдоно. Стратегийн нөхцөл байдал гэдэг нь тухайн улсын зорилго, орчин, хүчний харьцаа, боломж, хязгаарлалтын бодит төлөв байдлын нэгдсэн илэрхийлэл мөн. Энэ түвшинд үндэсний аюулгүй байдлын асуудал нь ямар аюул байна вэ гэсэн асуултаас илүү ямар нөхцөл байдал бүрэлдэж байна вэ гэсэн асуултаар тайлбарлагдана. Иймээс стратегийн нөхцөл байдал нь стратегийн уншлагын төв тайлбарлах нэгж болдог.

Стратегийн зорилго, боломж, хязгаарлалт. Стратегийн нөхцөл байдал тодорхой болсны дараа стратегийн зорилго, боломж, хязгаарлалтын харилцаа тодорч эхэлдэг. Зорилго нь хүрэхийг хүсэж буй үр дүнг илэрхийлдэг бол боломж нь тухайн зорилгод хүрэхэд ашиглаж болох нөхцөл, нөөц, давуу талуудыг, хязгаарлалт нь зорилго хэрэгжих боломжийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг тус тус илэрхийлнэ. Эдгээрийн харилцан үйлчлэлийн үр дүнд бодит стратегийн сонголтууд тодорхойлогддог. Иймээс стратегийн сонголт нь дур зоргын шийдвэр бус, харин зорилго, боломж, хязгаарлалтын огтлолцлоос урган гардаг үр дүн юм.

Стратегийн чиглэл. Эцэст нь сонгогдсон стратегийн чиглэл нь үндэсний аюулгүй байдлын бодит үр дүнд нөлөөлнө. Энэ утгаараа үндэсний аюулгүй байдал нь аюулын эсрэг хамгаалалтын эцсийн төлөв бус, харин стратегийн орчныг зөв уншиж, бодит нөхцөлд нийцсэн сонголт хийх төрийн чадварын үр дүн гэж

ойлгогдоно. Иймээс энэхүү аналитик загварын дагуу үндэсний аюулгүй байдлыг аюулын шинж чанараар бус, харин стратегийн нөхцөл байдлыг зөв тайлбарлаж, түүнд нийцсэн сонголт хийх чадвараар ойлгох боломжтой болно.

Энэ утгаараа стратегийн уншлага нь аюул төвтэй шинжилгээг орлохгүй боловч түүнийг илүү өргөн стратегийн хүрээнд байршуулж, үндэсний аюулгүй байдлыг аюулын түвшнээс нөхцөл байдлын түвшинд, эрсдэлийн үнэлгээнээс стратегийн утгын тайлбарын түвшинд авч үзэх аналитик боломжийг бүрдүүлж байна.

Энэ загвар нь өмнөх судлаачдын хэрэглэсэн нэгэн бэлэн загварыг хуулбарласан хэрэг биш бөгөөд стратегийн онолын сонгодог бүтээлүүдэд нийтлэг байдлаар давтагддаг аналитик элементүүдийг ойлголтын шинжилгээ (Sartori, 1970; Collier & Mahon, 1993; Goertz, 2006) болон онолын нэгтгэлийн аргаар дахин зохион байгуулсан зохиогчийн аналитик загвар мөн.

Энэхүү аналитик загварын шинэлэг тал нь зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголт зэрэг ойлголтыг шинээр нэвтрүүлж байгаад бус, харин тэдгээрийг үндэсний аюулгүй байдлыг тайлбарлах нэгтгэсэн стратегийн уншлагын хүрээнд холбон тайлбарлаж байгаад оршино.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Стратегийн уншлагын онол-арга зүйн үндсийг тодорхойлж, түүний аналитик загварыг боловсруулсны үндсэн дээр энэхүү хандлагын Монголын стратегийн судалгаа болон үндэсний аюулгүй байдлын бодлогод өгөх ач холбогдлыг авч үзнэ.

Монголын стратегийн судалгаанд оруулж буй онол-арга зүйн хувь нэмэр

Монгол Улсад үндэсний аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн судалгаанууд нь аюул занал, эрсдэл, хамгаалалтын асуудлыг тодорхойлох чиглэлээр мэдлэгийн чухал суурь бүрдүүлж ирсэн бөгөөд энэ нь аюулгүй байдлын орчны өөрчлөлтийг таних, эрсдэлийн шинж чанарыг тодорхойлох, хамгаалах шаардлагатай үнэт зүйлсийг илрүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсан байна. Иймээс аюул төвтэй шинжилгээ нь үндэсний аюулгүй байдлын судалгааны салшгүй бүрэлдэхүүн хэвээр бөгөөд аюулгүй байдлын асуудлыг ойлгох суурь тайлбарын хүрээг бүрдүүлсээр байна.

Гэвч орчин үеийн аюулгүй байдлын асуудлууд улам бүр олон хүчин зүйлийн огтлолцол, харилцан хамаарал, урт хугацааны өөрчлөлтийн нөлөөн дор бүрэлдэх болсон нөхцөлд аюулыг тодорхойлох болон эрсдэлийг үнэлэх нь асуудлын зөвхөн нэг талыг тайлбарлах боломжтой болж байна. Учир нь үндэсний аюулгүй байдлын олон асуудал нь ямар аюул нүүрлэж байгаагаас гадна ямар зорилго дарамтад орж байгаа, орчин ямар чиглэлээр өөрчлөгдөж байгаа, ямар боломж болон хязгаарлалт шинээр бий болж байгаа зэрэг илүү өргөн хүрээний асуудлыг хамардаг. Иймээс аюулын шинжилгээг орлох бус, харин түүнийг нөхөж, өргөжүүлэх арга зүйн нэмэлт хүрээ шаардлагатай болж байна.

Энэ хүрээнд энэхүү судалгааны оруулж буй хувь нэмэр нь стратегийн уншлагыг аюулгүй байдлын асуудлыг тайлбарлах бие даасан аналитик хүрээ болгон томъёолсонд оршино. Стратегийн уншлага нь аюулгүй байдлын шинэ салбар, шинэ ангилал, эсвэл шинэ судлагдахуун санал болгодоггүй. Харин аюулгүй байдлын асуудлыг өөр өнцгөөс тайлбарлах боломж олгодог. Түүний гол онцлог нь аюулын шинж чанарыг тодорхойлоход бус, тухайн асуудлын стратегийн

утгыг ойлгоход чиглэдэгт оршино. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын асуудлыг тусгаарлагдсан үзэгдэл бус, харин зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголтын харилцааны хүрээнд авч үзэх боломжийг бүрдүүлдэг. Иймээс стратегийн уншлага нь судалгааны объектыг өөрчлөхгүйгээр түүнийг тайлбарлах түвшнийг өргөжүүлж буй арга зүйн байрлал мөн.

Энэ утгаараа стратегийн уншлага нь Монголын стратегийн судалгаанд шинэ асуудал нэмэхээс илүүтэйгээр одоо судлагдаж буй асуудлуудыг өөр түвшинд тайлбарлах боломжийг нээж байна. Тухайлбал, аюулын тайлбараас стратегийн тайлбар руу, эрсдэлийн үнэлгээнээс нөхцөл байдлын тайлбар руу, баримтын шинжилгээнээс стратегийн утгын шинжилгээ рүү шилжих арга зүйн боломжийг бүрдүүлж байна. Энэхүү судалгааны гол хувь нэмэр нь Монголын стратегийн судалгаанд шинэ судлагдахуун нэмэхэд бус, харин одоо судлагдаж буй асуудлыг стратегийн нөхцөл байдлын түвшинд тайлбарлах арга зүйн хүрээг томьёолсонд оршино.

Үндэсний аюулгүй байдлын бодлогод оруулж буй аналитик хувь нэмэр

Үндэсний аюулгүй байдлын бодлого нь зөвхөн аюул заналд хариу үзүүлэх арга хэмжээ боловсруулах үйл ажиллагаагаар хязгаарлагддаггүй. Түүний үндсэн асуудал нь өөрчлөгдөж буй орчны дунд үндэсний зорилгыг хэрхэн хамгаалж, хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал байдаг. Иймээс бодлого нь аюулыг тодорхойлохоос гадна тухайн зорилгыг хэрэгжүүлэх орчин, боломж, хязгаарлалт, сонголтын нөхцөлийг ойлгох шаардлагатай болдог.

Аюул төвтэй бодлогын хандлага нь аюулыг таних, эрсдэлийг үнэлэхэд чухал хэвээр байна. Гэвч бодлогын түвшинд шийдвэр гаргах асуудал нь зөвхөн аюулын шинж чанараар тодорхойлогддоггүй. Бодлого боловсруулагчид зорилгын эрэмбэ, нөөцийн хязгаар, орчны өөрчлөлт, хугацааны хүчин зүйлсийн дунд сонголт хийх шаардлагатай болдог. Иймээс аюулын тухай мэдээлэл нь бодлогын асуудлын зөвхөн нэг хэсгийг тайлбарладаг ([Buzan 1991](#)).

Энэхүү судалгааны бодлогын түвшинд оруулж буй хувь нэмэр нь үндэсний аюулгүй байдлын асуудлыг аюулын үнэлгээнээс гадна зорилго, орчин, боломж, хязгаарлалт, сонголтын харилцан хамаарлын хүрээнд тайлбарлах аналитик боломжийг тодорхойлсонд оршино. Энэ хүрээ нь бодлого боловсруулагчдыг аюулын илрэлээс илүүтэйгээр зорилго, орчин, боломж, хязгаарлалт, хугацааны хүчин зүйлсийн харилцан нөлөөллийг авч үзэхэд чиглүүлдэг. Ингэснээр бодлогын асуудал нь зөвхөн ямар аюул үүсэж байна вэ гэсэн асуултаар бус, ямар сонголт бодитой бөгөөд ямар үр дагавар дагуулах вэ гэсэн асуудлаар тодорхойлогдох боломжтой болдог.

Энэ утгаараа стратегийн уншлага нь бодлогын асуудлыг хэсэгчилсэн бус, харин бүхэлд нь харах боломж бүрдүүлдэг. Мөн эрсдэлийн үнэлгээг зорилгын хүрээнд, боломжийг хязгаарлалтын хүрээнд, сонголтыг урт хугацааны үр дагаврын хүрээнд ойлгох нөхцөл бүрдүүлдэг. Иймээс үндэсний аюулгүй байдлын бодлого нь аюулын ангилал эсвэл эрсдэлийн бүртгэл төдий бус, харин зорилго, орчин, нөөц, хугацаа, сонголтын харилцан хамаарлыг ойлгох асуудал болох нь илүү тодорхой харагдана.

Ийнхүү стратегийн уншлага нь үндэсний аюулгүй байдлын бодлогод шинэ

хэрэгсэл санал болгож байгаа бус, харин бодлогын асуудлыг ойлгох хүрээг өргөжүүлж байна. Энэ нь аюулыг үгүйсгэхгүйгээр түүнийг зорилго, орчин, боломж, сонголтын хүрээнд тайлбарлах боломж олгодог бөгөөд үндэсний аюулгүй байдлын бодлогыг илүү өргөн стратегийн нөхцөл байдлын хүрээнд ойлгох арга зүйн үндэс болж байна.

Энэхүү судалгааны үр дүнд: (1) аюул төвтэй уншлага болон стратегийн уншлагын аналитик ялгааг онолын түвшинд тодорхойлов; (2) стратегийн уншлагын танин мэдэхүйн байрлал болон үндсэн асуултын тогтолцоог томъёолов; (3) үндэсний аюулгүй байдлыг стратегийн нөхцөл байдлын түвшинд тайлбарлах аналитик хүрээг санал болгов.

Энэхүү судалгаань стратегийн уншлагын онол-арга зүйн хүрээг боловсруулахад чиглэсэн тул түүний практик хэрэглээ, бодлогын шийдвэрт үзүүлэх нөлөө болон эмпирик баталгаажуулалтыг энэ өгүүллийн хүрээнд авч үзээгүй. Эдгээр асуудал нь цаашдын судалгааны бие даасан чиглэл болно.

ДҮГНЭЛТ

Орчин үеийн стратегийн орчин дахь харилцан хамааралтай, олон түвшний, тасралтгүй өөрчлөгдөж буй үйл явцууд нь үндэсний аюулгүй байдлын асуудлыг зөвхөн аюул занал, эрсдэлийн ангиллын хүрээнд тайлбарлах уламжлалт хандлагын тайлбарлах чадавхыг харьцангуй хязгаарлаж байна. Аюул төвтэй уншлага нь аюулыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, хамгаалалтын арга хэмжээ боловсруулахад ач холбогдлоо хадгалсаар байгаа боловч үндэсний аюулгүй байдлын олон асуудал нь дан ганц аюулын илрэл бус, харин илүү өргөн хүрээний стратегийн нөхцөл байдлын үр дүн болох нь харагдаж байна. Иймээс үндэсний аюулгүй байдлыг ойлгох асуудал нь зөвхөн ямар аюул үүсэж байна вэ гэсэн асуулгаар хязгаарлагдахгүй бөгөөд тухайн аюулыг бүрдүүлж буй нөхцөл байдал, чиг хандлага, боломж, хязгаарлалт, үр дагаврын харилцан хамаарлыг тайлбарлах шаардлага урган гарч байна.

Энэ хүрээнд өгүүлэлд дэвшүүлсэн стратегийн уншлага нь аюулыг тодорхойлох арга, баримтыг тайлбарлах арга, эсвэл төлөвлөгөө боловсруулах арга бус, харин үндэсний аюулгүй байдлын асуудлыг стратегийн нөхцөл байдлын түвшинд ойлгох танин мэдэхүйн болон аналитик байрлал болохыг харуулахыг зорив. Стратегийн уншлагын төвд аюул бус, харин зорилго, орчин, боломж, хязгаарлалт, чадавх, сонголтын харилцан хамаарлаар бүрэлдэх стратегийн нөхцөл байдал оршдог. Иймээс стратегийн уншлага нь үйл явдлыг бус нөхцөл байдлыг, аюулыг бус стратегийн орчныг, баримтыг бус стратегийн утгыг тайлбарлахад чиглэдэг бөгөөд үндэсний аюулгүй байдлыг стратегийн түвшинд ойлгох онол-арга зүйн үндсийг бүрдүүлж байна.

Судалгааны үр дүнд аюул төвтэй уншлага болон стратегийн уншлагын ялгааг системтэйгээр тодорхойлж, үндэсний аюулгүй байдлын стратегийн уншлагын аналитик загварын үндсэн логикийг боловсруулав. Энэхүү загвар нь үндэсний аюулгүй байдлын асуудлыг аюулын шинж чанараар бус, харин стратегийн нөхцөл байдал, зорилго, боломж, хязгаарлалт, сонголтын харилцан хамаарлын хүрээнд тайлбарлах боломжийг харуулж байна. Энэ утгаараа стратегийн уншлага нь Монголын стратегийн судалгаанд шинэ судлагдахуун нэмэхээс илүүтэйгээр одоо

судлагдаж буй асуудлуудыг өөр түвшинд тайлбарлах арга зүйн боломжийг нээж, үндэсний аюулгүй байдлын шинжилгээ болон бодлогын асуудлыг илүү өргөн хүрээнд ойлгох аналитик суурь болж чадна.

Иймээс үндэсний аюулгүй байдлыг ойлгох асуудал нь аюулыг тодорхойлох асуудлаас илүү стратегийн нөхцөл байдлыг унших асуудал болж өөрчлөгдөж байгаа бөгөөд энэхүү өөрчлөлтийг тайлбарлах онол-арга зүйн нэг боломж нь стратегийн уншлага мөн.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Baldwin, David A. 1997. “The Concept of Security.” *Review of International Studies* 23 (1): 5–26. JSTOR. <http://www.jstor.org/stable/20097464>.
2. Buzan, Barry. 1991. *People, States and Fear*. Lynne Rienner. 1–38.
3. Collier, David, and James Mahon. 1993. “Conceptual ‘Stretching’ Revisited: Adapting Categories in Comparative Analysis.” *American Political Science Review* 87 (4): 845–55. <https://doi.org/10.2307/2938818>.
4. Freedman, Lawrence. 2013. *Strategy: A History*. Oxford University Press.
5. George, Alexander L., and Andrew Bennett. 2005. “Case Studies and Theory Development in the Social Sciences.” *Cambridge, MA: MIT Press*, 3–36.
6. Gray, Colin S. 1999. *Modern Strategy*. Oxford: Oxford University Press. 17–32.
7. Gray, Colin S. 2010. *The Strategy Bridge: Theory for Practice*. Oxford University Press.
8. Heuser, Beatrice. 2010. *The Evolution of Strategy*. Cambridge University Press.
9. Rumelt, Richard. 2011. *Good Strategy/Bad Strategy*. New York: Crown Business. 77–90.
10. Ullman, Richard H. 1983. “Redefining Security.” *International Security* 8 (1): 129–53. JSTOR. <https://doi.org/10.2307/2538489>.
11. Wæver, Ole. 1995. “Securitization and Desecuritization.” In *On Security*, edited by Ronnie D. Lipschutz. Columbia University Press. 46–87, ISBN 978-0-231-10271-1.
12. Walt, Stephen M. 1991. “The Renaissance of Security Studies.” *International Studies Quarterly* 35 (2). 211–239. <https://doi.org/10.2307/2600471>.
13. Yarger, Harry R. 2006. *Strategic Theory for the 21st Century: The Little Book on Big Strategy*. Carlisle: Strategic Studies Institute. 43–56.
14. А.А. Свечин. 1927а. *Стратегия*. Москва: Военный вестник.
15. А.А. Свечин. 1927б. “Сущность стратегии.” In *Стратегия*. Сущность стратегии. Москва: Военный вестник.
16. *Аюулгүй байдал, стратеги тойм*. 2023. №28–35. Стратеги судалгааны хүрээлэн.
17. Б.Ширнэн. 2025. “Улсыг батлан хамгаалах стратегийн нэг нь орон нутгийн хамгаалалт мөн.” *Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал* 41(51): 94–100.
18. Кокошин А.А. 2014. *Стратегическое управление: теория, исторический опыт, сравнительный анализ и задачи для России*. Москва: РОССПЭН. 17–39.
19. Кокошин А.А. 2019. “Вопросы прикладной теории войны.” Москва: Издательский дом Высшей школы экономики. 41–67.
20. Снесарев А.Е. 2002. “Философия войны.” Москва: Финансовый контроль.
21. С.Пүрэвдорж. 2025. “Аюулгүй байдлыг цэргийн аргаар хангах онолын судалгааны өөрчлөлт, хандлага.” *Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал* 41(51): 111–23.